

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ САЙДТАЙ
2024 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 10

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хууль эрх зүйн хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.


ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 48 үүргийг хүлээж, үүргийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар жилийн эцсийн хэрэгжилт 96 хувьтай хэрэгжүүлсэн байна. Үүнээс 100 хувь-44, 70 хувь -3, 0 хувьтай-1 заалт хэрэгжсэн байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд нийт 3,766,5 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс Улсын төсвөөс 403,7 сая, Орон нутгийн төсөв 3,362,8 сая төгрөг байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 3421 иргэнд тоон гарын үсэг олгосноос 11 дугаар сард 215 иргэнд тоон гарын үсэг олгосон. Тоон гарын үсгийг 1295 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 2126 иргэнд гар утасны sign апплейшнаар дамжуулан нийт 22760 иргэнд олгож 71,03 хувьтай байна. Хулд суманд зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөрлөг, Өлзийт суманд зохион байгуулагдсан Малчны өдөрлөгт оролцон нийт 58 иргэнд тоон гарын үсэг олгосон.



“Аюулгүй орчин-Бидний хүсэл” хэлэлцүүлгийг зохион байгуулан төрийн 6 байгууллагаас 25 алба хаагч, Ерөнхий боловсролын 5 сургуулийн 20 сурагч оролцож гарсан саналыг хэрэгжүүлэн Ерөнхий боловсролын сургуулиудын орчинд шинэлэг шийдэлтэй, цагийн тохиргоогоор ажиллах, явган хүний гэрэлтүүлэгтэй гарцыг байршуулсан. Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 2 ерөнхий боловсролын сургуулийн орчинд явган хүний гэрлэн дохио суурилуулах ажлын шаардагдах 54,273,800 төгрөгийн төсвийг шийдвэрлэж ашиглалтад оруулсан.



“Аймгийн төвийн нэгдсэн камержуулалт”-ыг орон нутгийн хөгжлийн сангийн 1,8 тэрбум төгрөгөөр баталж тендэр шалгаруулалтыг зарлан “Бодь-Электроникс” ХХК-ний тендэрийг хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулж гэрээ байгуулах эрх олгохоор мэдэгдэл хүргүүлсэн. “Камерын нэгдсэн удирдлагын төвийн байрны их засвар” төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн 824,5 сая төгрөгийн төсөвт өртгөөр санхүүжүүлэхээр баталж

Сүлд оюу хайрхан” ХХК-ний ирүүлсэн тендэрийг хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулсан.Нийт 2.7 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас хийгдсэн байна.

The left screenshot shows a tender page for 'Сүлд оюу хайрхан' LLC. The right screenshot shows a list of items for sale, including Toyota Land Cruiser vehicles and other equipment.

№	Эмгэгдлийн нэр	Салбар дүнгийн үнэ	Төлбөр	Байршил	Мэдээлэл
1	Тойота Ланд Крузер	1,718,381,000	1,718,381,000	1,718,381,000	2024.01.25
2	Давууны насос	1,868,111,000	1,868,111,000	1,868,111,000	2024.01.25
3	Тойота Ланд Крузер	1,868,111,000	1,868,111,000	1,868,111,000	2024.01.25
4	Тойота Ланд Крузер	1,868,111,000	1,868,111,000	1,868,111,000	2024.01.25
5	Тойота Ланд Крузер	1,868,111,000	1,868,111,000	1,868,111,000	2024.01.25

Аймгийн төвд эргүүл шалгалтад ашиглах суудлын Приус-30 маркын автомашиныг 30.0 сая төгрөг, цагдаагийн газрын парк шинэчлэлтэд зориулж, 130.0 сая төгрөгний өртөг бүхий туулах чадвар сайтай “Ланд-200” маркын автомашин шийдвэрлэж, хүлээлгэн өгсөн.



Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн санхүүжилтээс 19.8 сая төгрөг шийдвэрлэж Монгол Улсын Их хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль болсонтой холбогдуулан сонгуулийн үеийн аюулгүй байдлыг хангах, хэв журмын болон замын хамгаалалтын үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчдад нэн шаардлагатай 50 ширхэг радио станц, энгэрийн камераар алба хаагчдыг



хангасан.

Төрийн үйлчилгээг ард иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай, тэгш, хүртээмжтэй хүргэх, эрүү, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг цаг алдалгүй явуулах зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар тус газрын албан хэрэгцээнд зориулан 25,0 сая төгрөгний өртөг бүхий Prius-30 маркийн тээврийн хэрэгслийг хүлээлгэн өгсөн.



Хоригдол, баривчлагдсан этгээд, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Сургалтын өрөө”, “Нийгмийн ажилтны өрөө”-г засварлан, тохижуулах ажилд 5,0 сая төгрөг шийдвэрлэсэн. Ингэснээр хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдахын зэрэгцээ гэмт хэрэг, зөрчилд дахин холбогдохоос урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эерэг уур амьсгал бүрдүүлэх юм.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 25.0 сая төгрөгийн үнэ бүхий 37 нэр төрлийн химийн лабораторын техник, тоног төхөөрөмж, Химийн шинжилгээний лаборатори шинээр байгуулагдаж байгаатай холбогдуулан шаардлагатай нэмэлт тоног төхөөрөмжид шаардлагатай 6.3 сая төгрөгийг шийдвэрлэсэн.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 96 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Аймаг орон нутагт хэрэгжилтийн хангах боломжгүй 1 заалт байна. Үүнд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын орон нутаг дахь газар, нэгжүүд, сумын Засаг дарга нартай тодорхой арга хэмжээ гүйцэтгүүлэх гэрээ болон тухайн салбарын байгууллагын ерөнхий менежертэй гэрээ байгуулан ажиллах үүрэг нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх арга хэмжээ байхгүй байсан тул тусгайлсан гэрээ байгуулагдаагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон төрөлт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулснаар тухайн төрлийн гэмт хэрэг мал хулгайлах гэмт 1 бүртгэгдсэн нь өмнө оны мөн үеэс 1 нэгжээр буюу 50 хувиар буурсан ба хэргийн илрүүлэлт 100 хувьтай хэрэгжсэн нь буурсан эерэг үзүүлэлттэй байна.

“Аймгийн төвийн нэгдсэн камержуулалт”-ыг орон нутгийн хөгжлийн сангийн 1,8 тэрбум төгрөгөөр баталж “Камерын нэгдсэн удирдлагын төвийн байрны их засвар” төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн 824,5 сая төгрөгийн төсөвт өртгөөр санхүүжүүлэхээр баталсан. Орон нутгийн хөгжлийн сангаас нийт 2.7 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас хийгдсэн байна.

Цагдаагийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зэрэг арга хэмжээнд нийт зарцуулсан төсвийн 80,4 хувийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн нь гэрээгээр хүлээх үүргийн хэрэгжилтэд аймаг орон нутгаас бодит үр дүнг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж болохоор байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Хууль эрх зүйн хэлтэст:

1.Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших мөн нотлох баримтыг тайланд хавсаргаж байх

2.Дараа оны гэрээний төсөлд төсөв хөрөнгө нь тодорхой, үр дүн гарахуйц аймаг орон нутагт хэрэгжилтийг хангаж ажиллах боломжтой бодитой ажлуудыг тусгах саналыг яам руу уламжлах.

БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.МӨНХЧУЛУУН

ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА

Д.ДААРИЙМАА

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.МЯГМАРМЯДАГ